



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/512

Арвайхээр


### Шагнах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Засаг даргын 2008 оны 185 дугаар захирамжаар батлагдсан “Нэрэмжит шагналын журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уянга сумын Жаргалант багийн ерөнхий боловсролын сургуулийн 70 жилийн ойг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл гарган, үр бүтээлтэй ажиллаж буй багш Б.Чимэд, Т.Энхчимэг, ажилтан Б.Пүрэв, А.Энхтүвшин, Бүрд сумын Эрүүл мэндийн төвийн 80 жилийн ойг тохиолдуулан ахмад настан Д.Үрмаа, Н.Цэцгээ, сувилагч Т.Гансүх, мал аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Баянгол сумын малчин Д.Баасандорж, Ш.Ганбат, А.Тунгалаг нарыг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр, Цагдаагийн газрын түүхт 80 жилийн ойг тохиолдуулан ахмад настан П.Даваадорж, Н.Соёл-Эрдэнэ, Я.Батсайхан нарыг Богд хаант Монгол Улсын анхны Ерөнхий сайд, Сайн ноён хан Төгс-Очирын Намнансүрэнгийн нэрэмжит “Төрийн шилдэг түшээ” тэмдэг-ээр тус тус шагнасугай.

2. Журмын дагуу дагалдах 510.000 (таван зуун арван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100888